

Өргөдөл гаргахад анхаарах зүйлс (доорх 4 улс)

АВК Япон хэлний сургууль 2018 он 7-дугаар сар

Бангладеш, Монгол, Непал, Шри-Ланка улсын иргэд өргөдөл гаргахад олон төрлийн бичиг баримт шаардлагатай тул энэхүү зааврыг сайн уншиж танилцсаны үндсэн дээр өргөдөл гаргана уу!

1. Өргөдөл гаргагчид тавигдах шаардлага

Хамгийн сүүлд төгссөн сургууль 5 жил дотор байх, Японд сурах зорилго нь тодорхой байх, Японд сурахад зарцуулагдах сургалтын төлбөр, амьдрах зардлыг төлөх санхүүгийн чадвартай эсвэл Японд сурах үедээ хичээлд саад болохооргүй хэмжээнд цагийн ажил нэмж хийхэд сургалтын төлбөр, амьдрах зардалд хүрэлцэхүйц хэмжээний санхүүгийн чадамжтай болох.

2. Бүрдүүлэх материал (Сургуульд элсэгчидэд тавигдах шаардлагын хамт харна уу)

“Өргөдөл гаргагчтай холбоотой материал”, “Батлан даагчтай холбоотой материал”, “Эцэг эхийн талаарх мэдээлэл” гэсэн 3 төрлийн бичиг баримт хэрэгтэй. Японы цагаачлалын албанд хураалгах үед, Японд олгогддог болон Японоос өөр улсаас авдаг бичиг баримт бол 3 сарын дотор хийсэн байх ёстойг анхаарна уу! 4 сарын элсэлтийн материалыг 12 сарын эхээр, 10 сарын элсэлтийн материалыг 6 сарын эхээр Японы цагаачлалын албанд хураалгадаг болно.

I. Өргөдөл гаргагчтай холбоотой материал

(1) Сургуульд элсэх өргөдөл

- ① Сурсан түүх болон ажлын түүхийг бичихэд өвчин болон бусад шалтгааны улмаас ажиллаагүй, сураагүй хугацаа байгаа бол тусад нь тэр тухай тайлбар бичин хавсаргана уу! Тайлбарын загвар чөлөөтэй бөгөөд бөглөсөн он сар өдөр, овог нэрээ бичнэ үү!
- ② Сургуульд элссэн болон төгссөн он сар нь диплом, дүнгийн тодорхойлолттой таарж байх ёстойг анхаарна уу!
- ③ Гэр бүлийн тухай хүснэгтэнд хамт болон тусдаа амьдардагаас үл хамааран өөрийн эцэг эх, ах, эгч, дүү нарынхаа талаарх мэдээллийг үнэн зөвөөр бичнэ үү.

(2) Ахлах сургууль, их сургуулийн диплом ба дүнгийн тодорхойлолт (сурсан жил бүрийнх)

- ① Ахлах сургууль төгссөний дараа мэргэжлийн сургууль (коллеж) төгссөн бол
 - мэргэжлийн сургуулийн диплом (нотариатаар батлуулсан хуулбар)
 - дүнгийн тодорхойлолт (нотариатаар батлуулсан хуулбар)
 - ахлах сургууль төгссөн гэрчилгээ (эх хувь),
 - дүнгийн тодорхойлолтыг (эх хувь) хураалгана уу!
- ② Ахлах сургууль эсвэл их сургуульд сурж байгаа бол одоог хүртлэх бүх дүнгийн тодорхойлолтыг эх хувиар нь хураалгана уу!

(3) Япон хэлний мэдлэгийн тухай бичиг баримт

Япон хэлний түвшин тогтоох шалгалт N4 эсвэл N5 түвшинд тэнцсэн эсвэл тэр хэмжээний Япон хэлний мэдлэгтэй байх шаардлагатай. Доорх ① ба ②-ын аль нэгийг хураалгана уу!

- ① Япон хэл сурсан тодорхойлолт: Япон хэл 150 цагаас дээш сурсан тодорхойлолт. Тодорхойлолт дээр сурагчийн овог нэр, суралцсан хугацаа, хөтөлбөрийн нийт цаг, тус сурагчийн суусан нийт цаг, олгосон он сар өдөр, Япон хэлний сургуулийн нэр, хаяг ба холбоо барих утасны дугаар зэрэг бичигдсэн байх.
- ② Япон хэлний түвшин тогтоох шалгалт N4 эсвэл N5-аас дээш түвшинд тэнцсэн бичиг.

※Дээрхээс гадна ВЈТ буюу Бизнесийн Япон хэлний шалгалт, Жэй-тест (J-Test), Япон хэлний NAT төстийн хариу байвал хураалгана уу!

- (4) Өмнө нь Япон улсад ирж байсан бол түүний талаарх тайлбар
Өмнө нь Япон улсад 1 сараас дээш хугацаагаар ирж байсан бол Япон улсад байсан хугацаа (олон удаа ирж байсан бол бүгдийг нь бичих), визний төрөл, зорилго, байрласан газар (хаяг, утас), гарсан зардал, зардлыг төлсөн хүний нэр болон өргөдөл гаргагчтай ямар хамааралтай болох тухай бичиж (загвар чөлөөтэй, бичсэн он сар өдөр, нэрээ өөрийн гараар бичих) хавсаргах.
- (5) Гэр бүлийн гишүүдийн иргэний үнэмлэхний хуулбар
Гэр бүлийн бүх гишүүдийн иргэний үнэмлэхний хуулбар. Иргэний үнэмлэх дээрх мэдээлэл хамгийн сүүлийн шинэ мэдээлэл байх ёстой. Гэр бүлийн гишүүдийн сурсан түүх, ажил мэргэжлийг бичсэн байвал сайн.

II. Батлан даагчтай холбоотой материал

Япон улсад сурах зардлыг хэн төлөхөөс хамаарч дараах А эсвэл В-д заасан материалыг хураалгана. Батлан даагч нь өргөдөл гаргагчтай төрөл садангийн холбоотой байх ёстой бөгөөд танил болон найз нөхдийн хамааралтай байж болохгүй. (Тэтгэлэгт хамрагдсан зэрэг тусгай хөтөлбөрт хамрагдаж байгаа тохиолдолд батлан даагч өргөдөл гаргагчтай төрөл садангийн холбоотой байх шаардлагагүй)

А. Япон улсаас өөр улсад суугаа төрөл садан нь амьдрах зардал болон сургалтын төлбөрийг төлөх тохиолдолд

Тус сургуульд 1 жил эсвэл сурахаар төлөвлөсөн хугацаанд сургалтын төлбөр, амьдрах зардлыг төлж чадахуйц санхүүгийн чадвартайг батлах дансны тодорхойлолт хэрэгтэй.

- (1) Батлан даагчийн бичиг
Заавал батлан даагчаараа бөглүүлэн гарын үсэг зуруулна уу!
- (2) Батлан даагчийн гэр бүлийн талаарх хүснэгт
Эхнэр нөхөр, хүүхэд (хамт болон тусдаа амьдардаг эсэхийг үл харгалзан), мөн хамтран амьдардаг хүн зэргийг мэдээллийг бүгдийг нь үнэн зөвөөр бичнэ уу. Батлан даагч нь хүснэгт бичсэн өдөртөө гарын үсгээ зурсан байх.
- (3) Дансны тодорхойлолт
Дансны тодорхойлолтыг эх хувиар нь хураалгах шаардлагатай бөгөөд хуулбар эсвэл нотариатаар батлуулсан хуулбар байж болохгүй. Сурагчийг Японд байх нийт хугацааны сургалтын төлбөр болон амьдрах зардлыг бүрэн төлөхүйц хэмжээнээс дээш дансны үлдэгдэлтэй байх шаардлагатай.
- (4) Дансны хуулга эсвэл банкны дэвтрийн хуулбар
(3)-ын дансанд хэзээ, хэдий хэмжээний мөнгө орж гарсан тухай дансны хуулга эсвэл банкны дэвтрийн хуулбар. Банкны дэвтрийн данс эзэмшигчийн овог нэр, банкны нэр, дансны дугаар, банкны дэвтрийн дугаартай хуудсын хуулбар мөн хэрэгтэй. Өнгөрсөн 3 жилийн турш, эсвэл данс нээсэн өдрөөс хойш өнөөг хүртэлх хугацааных болно.
А дансаа хаалган Б дансанд хадгаламжаа шилжүүлсэн зэрэг тохиолдолд, А болон Б дансны хуулбарыг хамтад нь хураалгах шаардлагатай!
- (5) Ажлын газрын тодорхойлолт
Батлан даагчийн албан тушаал, ажилласан хугацаа, ажлын газрын хаяг, утас, тодорхойлолт олгосон хүний нэр, албан тушаал, тодорхойлолт олгосон он сар өдөр зэргийг бичсэн байх.
Компаний лого зэрэгтэй толгойтой цаасан дээр хэвлэсэн байх.

(6) Жилийн орлогын тодорхойлолт (сүүлийн 3 жилийнх, хүснэгтээр)

Үндсэн цалин, урамшуулал (13 дахь сарын цалин гэх мэт), татвар төлсний дараах цалин, ажлын газрын хаяг, утас, тодорхойлолт олгосон хүний нэр, албан тушаал, тодорхойлолт олгосон он сар өдөр зэргийг тодорхой бичсэн байх. Компаний лого зэрэгтэй толгойтой цаасан дээр хэвлэсэн байх.

(7) Татвар төлсөн баримт (сүүлийн 3 жилийнх)

Татварын газраас авсан албан ёсны бичиг байх ёстой.

(8) Бусад

Ажилладаг газрын эсвэл эзэмшдэг компаний тухай мэдээлэл авч болохуйц компаний танилцуулга, товхимол зэрэг.

В. Япон улсад суугаа төрөл садан нь амьдрах зардал болон сургалтын төлбөрийг төлөх тохиолдолд

(1) Батлан даагчийн бичиг

Заавал батлан даагчаараа бөглүүлэн гарын үсэг зуруулна уу!

“Батлан дааж байгаа шалтгаан ба мөнгө шилжүүлэх арга” хэсгийг бөглөхөд “хавсралтыг үзнэ үү” гэснийг сонгон, өөр цаасан дээр доорх ①-④-ийг аль болох дэлгэрэнгүй бичнэ үү! (он сар өдөр, овог нэрээ бичин батлан даагчийн бичиг дээрхтэй адилхан гарын үсэг зурах, загвар чөлөөтэй)

① Өргөдөл гаргагчтай ямар хамааралтай болох

② Мөнгөний эх үүсвэр

Ялангуяа батлан даагч нь компаний захирал, хувийн бизнес эрхлэгч бол яг юу хийдэг болох, компаний үйл ажиллагааны цар хүрээ, яаж компани байгуулсан тухай, компаний орлого ба хувийн орлогын талаар дэлгэрэнгүй бичих.

③ Өргөдөл гаргагчийн Японд сурах зорилго

④ Батлан даах шалтгаан (мөн эцэг эх тань яагаад батлан даах боломжгүй талаар бичнэ үү)

“Батлан даах мөнгөн дүн ба мөнгө шилжүүлэх арга” хэсгийн тухай

- Амьдрах зардал: Сар бүр амьдрах зардалд өгөх мөнгөний хэмжээ

- Мөнгө шилжүүлэх арга: Сургалтын төлбөр, амьдрах зардлыг яаж шилжүүлэхээ бичих.

Өргөдөл гаргагч нь Японд ирснээс хойш батлан даагчийн бичиг дээрх дагуу мөнгөө авч байгааг Японы цагаачлалын албанд батлан харуулах шаардлагатай тул банкаар шилжүүлэх гэснийг сонгоно уу.

(2) Батлан даагчийн гэр бүлийн талаарх хүснэгт

Эхнэр нөхөр, хүүхэд (хамт болон тусдаа амьдардаг эсэхийг үл харгалзан), хамтран амьдардаг хүн зэргийг бүгдийг нь үнэн зөвөөр бичнэ үү. Батлан даагч нь хүснэгт бичсэн өдөр гарын үсгээ зурсан байх.

(3) Дансны тодорхойлолт

Япон дахь банкны дансны тодорхойлолтын эх хувь. . Сурагчийг Японд байх нийт хугацааны сургалтын төлбөр болон амьдрах зардлыг бүрэн төлөхүйц хэмжээнээс дээш дансны үлдэгдэлтэй байх шаардлагатай.

(4) Дансны хуулга эсвэл банкны дэвтрийн хуулбар

(3)-ын дансанд хэзээ хэдий хэмжээний мөнгө орж гарсан тухай дансны хуулга эсвэл банкны дэвтрийн хуулбар. Банкны дэвтэрний данс эзэмшигчийн овог нэр, банкны нэр, дансны дугаартай хуудсын хуулбар мөн хэрэгтэй. Өнгөрсөн 3 жилийн турш, эсвэл данс нээсэн өдрөөс хойш өнөөг хүртэлх хугацааных болно.

(5) Жилийн орлогын тодорхойлолт
Сүүлийн 3 жилийн татвар төлсөн баримт.

(6) Бусад

- ① Төрөл садангийн лавлагаа: Өргөдөл гаргагч ба батлан даагчийн хоорондын хамаарлыг батлах бичиг баримт.
- ② Гэрлэлтийн гэрчилгээний хуулбар: Өргөдөл гаргагч ба батлан даагчийн хоорондын хамаарлыг батлах бичиг баримт.

С. Өргөдөл гаргагч өөрөө төлбөр болон амьдрах зардлаа төлөх тохиолдолд

Манай сургууль одоогоор өөрөө төлбөрөө төлөх оюутны материалыг хүлээж авахгүй болно.

III. Эцэг эхийн талаарх мэдээлэл (Эцэг эх тань батлан даагч биш тохиолдолд)

- (1) Эцэг эхийн ажлын талаарх тодорхойлолт
- (2) Эцэг эхийн орлогын талаарх тодорхойлолт
- (3) Эцэг эхийн татвар төлсөн баримт
- (4) Эцэг эхийн дансны үлдэгдлийн тодорхойлолт
- (5) Эцэг эхийн дансны хуулга

3.Өргөдөл хүлээлгэж өгсөн хүний талаарх мэдээлэл

Тус сургууль дээр ирж өргөдлөө өгөх бол: Өргөдөл хүлээлгэж өгсөн хүний холбоо барих овог нэр, утасны дугаар зэргийг бөглүүлнэ.

Шуудангаар өргөдөл явуулах бол: Доорх зүйлсийг бичин өргөдөлтэйгөө хамт илгээнэ үү!

- ① Шуудангаар илгээсэн хүний овог нэр
- ② Өргөдөл гаргагчтай ямар хамааралтай болох
- ③ Холбоо барих хаяг, утас, факс, и-майл
- ④ Чухал бичиг баримт илгээж болох хаяг

4.Бусад

- (1) Бүх бичиг баримтанд засвар орсон байж болохгүй.
- (2) Бүх төрлийн тодорхойлолт дээр тодорхойлолт олгогчийн овог нэр, харьяалагдах байгууллагын нэр, хаяг, утас, факсыг бичсэн байх ёстой. Боломжгүй тохиолдолоос бусад тохиолдолд, тодорхойлолт олгогчийн гарын үсэгтэй байх шаардлагатай.
- (3) Япон эсвэл англи хэлнээс өөр хэл дээрх бичиг баримтанд япон эсвэл англи хэлний орчуулгыг хавсаргах.
- (4) Хураалгасан бичиг баримтны талаар тус сургуулиас утасдаж асууж лавлах зүйл гарж магадгүй тул хураалгасан бичиг баримтны хуулбарыг өөртөө хадгална үү!
- (5) Хуурамч бичиг баримт хуураалгасан нь илэрсэн тохиолдолд, сургуульд тэнцээгүйд тооцно.
- (6) Бүрдүүлэх бичиг баримтыг бүрэн хураалгасан ч тэнцэхгүй тохиолдол гарах тул өөр сургуульд давхар өргөдөл гаргаж болно. Өөр сургуульд давхар өргөдөл гаргах бол тэр тухайгаа мэдэгдэнэ үү!
- (7) Өмнө нь Японы цагаачлалын албанд оршин суух зөвшөөрөл мэдүүлээд татгалзсан хариу авч байсан эсвэл Японы виз мэдүүлээд татгалзсан хариу авч байсан бол татгалзсан шалтгааныг тодруулах шаардлагатай. Татгалзсан шалтгаанаас хамааран дахин виз хүсэх эрхгүй байх тохиолдол байх тул тэр тухайгаа мэдэгдэнэ үү!
- (8) Хураалгасан дипломны эх хувийг хариу гарсны дараа буцаан өгнө. Дипломноос бусад бичиг баримтыг буцааж өгөхгүй болно. Хэрэв буцааж авах хэрэгтэй бичиг баримт хураалгаж байгаа бол өргөдөл гаргах үедээ мэдэгдэнэ үү!